

8

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН АЛДАГДЛЫГ
БУУРУУЛАХ АРГА ЗҮЙН АСУУДАЛ

Б.Цэнгэлмаа

Оршил

Шинэчлэл хийсэн эхний жилүүдэд гарсан томоохон бэрхшээлүүдийн нэг нь Монгол улсын төсвийн тэнцэл жил тутам 10 гаруй тэрбум төгрөгийн алдагдалд орж, улс орны эдийн засгийн хямралд түлхэц өгч байсан. Төсвийн алдагдлыг бууруулах бодлогын хүрээнд манай улс олон арга хэмжээ хайж байгаагийн дотор зээл зарлагын бодлого зонхилж иржээ.

Гэвч зах зээлийн системд орсноос хойш тодорхой үр дүн төсвийн тэнцэл дээр ажиглагдсангүй. 1992 онд төсөв ашигтай гарсан боловч энэ нь зээлийн тодорхой хувь болохыг зээлийн үйл ажиллагаа нотолж байна.

1996 оноос эдийн засаг үргэлжилсэн уналтаас гарч, зарим нааштай үр дүн ажиглагдах болсон нь эдийн засгийн системийн зарим хүчин зүйлүүд тодорхой өөрчлөлтөд орж дэлхий нийтийн зах зээлтэй уялдаж эхэлсэн, гипер инфляцийн давалгаа намжсан, иргэд ямэр нэг хэлбэрээр өмч хөрөнгөтэй болсонтой холбоотой. Харин 2002 оноос авч хэрэгжүүлсэн Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн үр дүнд 2004-2005 онуудад төсвийн хүрээнд нааштай өөрчлөлт гарч төсвийн нийт тэнцэл 2004 онд ДНБ-нд -2.2 хувь 2005 онд -1.0 хувийг эзлэж байна.

Энэхүү сэдвийг судалгааныхаа объект болгон авч Монгол улсын төсвийн ерөнхий байдал болон төсвийн алдагдлыг бууруулах боломжуудыг эрэн сурвалжилж, түүнийг бууруулах шаардлага байгаа эсэх, байвал хэрхэн бууруулах талаар өөрийн үзэлээ тусгахыг оролдлоо. Судалгаандаа 1990-2005 оны төсвийн нэгтгэлийг ашиглаж, уг хугацаан дах төсвийн орлого, зарлагын үзүүлэлтүүдийн өсөлт бууралтын байдал тэдгээрийн ДНБ-нд эзлэх хувийн жинд нөлөөлөх хүчин зүйлийн судалгааг эконометрик шинжилгээний регресси, корреляцийн шинжилгээний EXCEL багц программыг ашиглан төсвийн

орлого зарлага болон алдагдлын ерөнхий хандлагыг шинжилж, өөрийн саналаа дэвшүүллээ. Энэ нь төсвийн алдагдлын уламжлалт шалтгааныг олж тогтооход нэлээд ач холбогдол өгсөн юм.

1. Монгол улсын төсвийн алдагдлын шинжилгээ

Төсвийн алдагдлын шалтгаан, үр дагвар

Улсын төсвийн зарлага нь орж ирэх орлогоосоо давсан нөхцөлд төсөв нь алдагдалд орно. Иймд төсвийн алдагдал нь үндсэндээ гол хоёр ерөнхий шалтгаантай буюу төсвийн орлого буурах эсвэл төсвийн зарлага санхүүжилт нэмэгдсэнээс үүснэ. Төсвийн орлогын бууралт нь татварын хувь хэмжээг засгийн газраас зориуд бууруулах, улс орны эдийн засгийн хямралт байдал болон татвар төлөгчдийн тоо хэмжээнээс шууд хамааралтай байдаг. Мөн татварын бус орлогын багасалт, төрийн өмчийн үйлдвэр, аж ахуй нэгжүүдийн үр ашигт үйл ажиллагаа гэх мэт олон хүчин зүйлээс хамаарч болно. Харин төсвийн зарлага санхүүжилтийн өсөлт нь тухайн улсын хөгжлийн түвшин эдийн засгийн нөхцөл байдал, засгийн газрыг хэрэгжүүлэх бодлого болон төсвийн орлогоос нягт уялдаатай байдаг. Хөгжиж байгаа орнуудын хувьд эдийн засгийн түргэн өсөлтийг олж авах зорилгоор хөрөнгө оруулалтаа өсгөх бодлого барьж зарлага санхүүжилтаа нэмэгдүүлэх хандлага сүүлийн үед их ажиглагдаж байна.

Төсвийн алдагдлыг гаргах янз бүрийн шалтгаан байдаг.

- Эдийн засгийн хямрал удаан үргэлжлэх
- Татвар төлөгч аж ахуй нэгжүүд санхүүгийн доройтолд орох
- Зайлшгүй шаарлагаар зарлагын эрэлт хэрэгцээ ихсэх, ялангуяа хөрөнгө оруулалтын санхүүжилт нэмэгдэх.
- Ер нь үйлдвэрлэлийн бус зориулалтын биш үр ашиггүй зарлага хэт ихсэх
- Нийгмийн болон байгалийн гэнэтийн үзэгдэл гарз хохирол сүйрлийн аюул тохиолдох
- Улс орны харилцаа холбоо бүхий гадаад эдийн засаг, улс төрийн харилцаанд сөрөг нөлөөлөл бүхий зохисгүй өөрчлөлт гарах зэрэг болно.

Төсвийн алдагдлыг нэлээд хэдэн янзаар ялган үзэж болно.

1. Урсгал тооцооноос гарах алдагдал
2. Гадаад хүчин зүйлсийн алдагдал
3. Урсгал зарлагын өсөлтийн алдагдал
4. Мөнгө зээлийн бодлогын алдагдал
5. Субъектив хүчин зүйлсийн алдагдал
6. Хөрөнгө оруулалтаас болж гарах алдагдал
7. Урсгал орлогын алдагдал
8. Он удаан жилийн алдагдал ба өрийн хямрал
9. Санхүүгийн буруу бодлогын алдагдал

Төсвийн алдагдлын үеийн бодлого

Бодлого	үүрэг	Үйлдэл	Нөлөөлөл
Сангийн	Анхдагч	ЗГ зээллэг хийнэ	Зээлийн хүү өснө ,ХО буурна
Мөнгөний	Туслах	Мөнгөний нийлүүлэлтийг ихэсгэнэ	Зээлийн хүү буурна ,ХО өснө

Макро түвшний ийм зохицуулалт нь засгийн газрын бодлогын үндэс байх ёстой Манай улсын хувьд төсвийн алдагдлын гол шалтгаан нь:

- Эдийн засгийн систем бүхэлдээ шинэчлэгдсэн.
- Инфляци ,ажилгүйдэл ихсэж үйлдвэрүүд уналтанд орсон.
- Урсгал зарлагын өсөлт урсгал орлогын бүрдүүлэлтээс түрүүлж алдагдлыг нэмэгдүүлсэн. (1990,1991)
- Гадаад зээл өр төлбөр ихтэй холбоотой гэж үзэж байгаа бөгөөд шилжилтийн орнуудад гарч байгаа төсөв , татварын алдаатай бодлого зохих хэмжээгээр нөлөөлсөн.

Төсвийн алдагдлын шалтгааныг судласны эцэст төсвийн алдагдлын үр дагавар , үзүүлэх нөлөөллийг судлах нь чухал юм

Иймээс дараах нөлөөллийг авч үзлээ.

Байгууллагын татварын хувь хэмжээг бууруулснаас үүдэж хэрэглээнд гарах нөлөө .

Байгууллагын ашгийн татварыг бууруулах нь ноогдол ашгийн хэмжээ өсөхөд нөлөөлөх бөгөөд энэ нь хэрэглээг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж болно . Гэхдээ ашгийн татварыг бууруулах нь ноогдол ашгийг өсгөхөөсөө илүү хуваарилагдаагүй ашиг өсөхөд хүргэх ба хувьцаа эзэмшигчид нь үүнийг мэдсэн тохиолдолд хэрэглээ өсөх боломжтой. Учир нь өөрийн эзэмшиж буй хөрөнгийн хэмжээ өсөх нь хүмүүст өөрсдөө баян болж буй мэт сэтгэгдэл төрүүлдэг бөгөөд энэ нь хэрэглээгээ өсгөхөд хүргэж болзошгүй.

Хөрөнгө оруулалт ба төсвийн алдагдал

Төсвийн зардал ба алдагдал нь хувийн хөрөнгө оруулалтыг бууруулдаг буюу түрэн гаргадаг гэсэн түгшүүртэй үзэл бодол агуулагдаж байдаг.

Хувийн хадгаламж ба хөрөнгө оруулалт

Тэнцвэрийн нөхцөлд хувийн хадгаламж ба хөрөнгө оруулалтын зөрөө нь алдагдалтай тэнцэнэ. Алдагдал өссөн үед улсын ба хувийн хөрөнгө оруулагчид нь боломжит хөрөнгийг нийлүүлэхийн төлөө өрсөлдөх бөгөөд энэ үед зээлийн хүү өсдөг. Зээлийн хүү их хэмжээгээр өсөх нь хөрөнгө оруулалтын өсөлтийг зогсоодог. Зөвхөн алдагдалтай тэнцүү хэмжээгээр хадгаламж өссөн тохиолдолд л зээлийн хүү өсөхгүй байж болно. Үүнийг зураг 1.3-аас харж болно.

Хэрэв алдагдалтай нэлээд их хэмжээтэй болоход хадгаламж тэр хэмжээгээр өснө. (өсөж буй алдагдлыг нөхөхийн тулд татвараа өсгөж магадгүй тул хадгаламжаа нэмэгдүүлж болох юм) гэсэн итгэл байх юм бол төсвийн алдагдлыг пропорционалаар өсгөж болно.

Төсвийг балансжуулах асуудал

Нээлттэй эдийн засаг дахь төсвийн алдагдал

Өнөөг хүртэл үндэсний хадгаламж нь хөрөнгө оруулалт ба өрийг санхүүжүүлэх ёстой гэж үзэж ирсэн. Харин төсвийн алдагдлыг гадаад зээлээр нөхөж болно гэж үздэг. Нээлттэй эдийн засаг алдагдалтай байх нь олон улсын зах зээл дээрх зээлийн хүүгийн хэмжээнд өөрчлөлт оруулж чадахгүй. Зээлийн хүүгийн түвшин өөрчлөгдөөгүй тохиолдолд хадгаламжтай хөрөнгө оруулалтын түвшин тогтвортой байна. Тиймээс алдагдлын үр дүнд гадаадын зээл өснө гэсэн үг бөгөөд энэ нь гадаадын засгийн газар эсвэл хувийн фирм байхаас үл хамаарна. Энэ тохиолдолд төсвийн алдагдал нь хөрөнгө оруулалтанд шууд нөлөөлөхгүй боловч ДНБ өсөхгүй бөгөөд ахиу үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн нь өрөө төлөхөд зарцуулагдана. Эндээс өнөөгийн төсвийн алдагдал нь ирээдүй үеийнхний хэрэглэх бүтээгдэхүүний хэмжээг бууруулж байна гэсэн дүгнэлтэнд хүрч болох бөгөөд энэ нь тухайн өр гадаадынх уу дотоодынх уу гэдгээс хамаарахгүй.

Төсвийн алдагдал ба улсын өрийн удирдлага

Манай орны хувьд төсвийн алдагдал нөхөх ерөнхий эх үүсвэр болгон авч ашиглаж буй өрийн асуудлыг ирээдүй хойч үедээ эргэн дарамт болохгүйгээр харж шийдвэрлэх нь чухал болоод байна.

Манай улс өнгөрсөн 15 жилийн хугацаанд олон улсын санхүүгийн байгууллага (ОУСБ) хандивлагч дэмжигч орнуудаас нийт 1.4 тэрбум ам долларын буцалтгүй тусламж, 1.5 тэрбум ам долларын зээл авсан. Мөн 1.3 тэрбум ам долларын гадаад хөрөнгө оруулалтыг 70 гаруй орноос авсан байна. Гадаадын зээл бол хожим зайлшгүй төлөгдөх улсын өр гэдэг нь ойлгомжтой.

Төсвийн алдагдлын тоон үзүүлэлт ба өр нь бодитойгоор дараах хүчин зүйлүүдээс шалтгаалж хүндэрч байдаг.

1.Ихэвчлэн улсын зарлагын хэмжээг үнэлэхдээ улсын эдийн засгийн секторт амортизацийг тооцоогүйгээс төсвийн алдагдлын болон улсын өрийн хэмжээ бодитойгоор нэмэгдэхэд хүргэж байна.

2. Улсын зардлын гол зүйл нь төлөх ёстой өрөндөө үйлчилж байна. Өөрөөр хэлбэл түүнд төлөх өрийн хувь ба үндсэн өрийн дүнг тогтмолоор төлж дуусгах ёстой. Улсын зардал улсын өрийн зөвхөн бодит хувийг шингээх ёстой.


Улсын төсвийн

Бодит алдагдал==УТ/Нэр/Алд Жилийн эхний улсын өрийн хэмжээ *
Алдагдлын хэмжээ

2. Монгол улсын төсвийн алдагдлын судалгаа

Монгол улс төсвийн алдагдлыг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд сүүлийн арван жилд зохих амжилтанд хүрч байна. Төсвийн урсгал зардал үнэмлэхүй дүнгээр болон нийт зардалд эзлэх хувиар өсч байгаа хэдий ч улсын салбарын үйлдвэрийн газарт олгох шууд татаас 1995-2002 онд 3 дахин буурсан. 2006 оны батлагдсан төсвөөр төсвийн нийт орлого 851.2 тэрбум, зарлага 935.0 тэрбум, нийт тэнцэл 84.0 тэрбум төгрөгний ашигтай байхаар төлөвлөгдсөн.

Нэгдсэн төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь, ДНБ-ний өсөлтийн харьцаа



Графикт: ДНБ-ний өсөлт нэгдсэн төсвийн тэнцэл, болон урсгал тэнцлийн ДНБ-д эзлэх хувийг харьцуулан авч үзлээ. Шилжилтийн эхний жилүүдэд эдийн засгийн бууралт явагдаж байхад төсвийн нийт болон урсгал тэнцэл нэлээд алдагдалтай. 1990-1992 онд нийт тэнцэл ДНБ-д (-13.4; -13.4) харьцаатай байсан байна. Эдийн засагт эхний сэргэлт харагдсанаар, 1994 оноос эдийн засгийн өсөлттэй болоход төсвийн нийт тэнцэл алдагдалтай хэвээр байсан ч урсгал тэнцэл алдагдалгүй гарч байна. Төсвийн нийт тэнцлийн алдагдлын хэмжээ сүүлийн таван жилд өмнөх арваад жилийнхийг бодвол буурах хандлагатай байгаа нь зургаас харагдаж байна. Сүүлийн таван жилд эдийн засгийн өсөлт тасралтгүй өсөх хандлагатай байсан бөгөөд үүнийг дагаад төсвийн урсгал тэнцэл эерэг үзүүлэлттэй болж ирлээ.

Монгол улсын төсвийн алдагдал /тэрбум төгрөгөөр /

	2000	2001	2002	2003	2004	2005
Урсгал тэнцэл	3146.4	32086.6	54.439.6	110.395.4	167.593.6	240.168.2
Нийт тэнцэл	-1099.44	-78655	-73.432.2	-61.882.0	-39.372.8	83.052.4

Монгол улсын төсвийн нийт тэнцэл 2004 онд -39.372.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч харин 2005 онд 83 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Төсвийн алдагдлыг ДНБ-ний аргаар шинжлэх нь орлогын бололцоог хэр ашиглаж байгааг харуулдаг. Ихэнх хөгжиж байгаа орнуудад ДНБ-нд эзлэх алдагдал, орлого зарлага өндөр байдаг бөгөөд экспорт ихсэхийн хэрээр энэ үзүүлэлтүүд буурдаг талтай. Манай нөхцөлд судалгаа хийж үзвэл:

ДНБ-нд эзлэх орлого, зарлага (2000-2005 он)(хувиар)

Үзүүлэлт	2000	2001	2002	2003	2004	2005
Нийт орлого	34.4	39.4	38.4	37.9	39.4	37.6
Нийт зарлага	42.2	43.9	44.4	42.1	41.6	33.9
Төсвийн алдагдал	-7.7	-4.5	-5.9	-4.2	-2.2	-1.0
ДНБ	100	100	100	100	100	100

Судалгаанаас үзэхэд: 2000 онд ДНБ-нд ногдох төсвийн алдагдал -7.7% болж өссөн бол 2001 онд буурч -4.5%, 2002 онд -5.9%, болж урьд оноос бага зэрэг өсөж, 2003 онд -4.2 байсан бол 2004 онд -2.2% болж огцом буурсан нь урьд өмнө нь гарч байгаагүй үзүүлэлт юм. Харин 2005 онд 1.0%, 2006 оны урьдчилсан гүйцэтгэлээр -3.4% байна. Дээрхээс харахад:

2001, 2003, 2004, 2005 онуудад ДНБ-нд ногдох төсвийн алдагдлын хувийн жин бага байгаа нь энэ онуудын төсвийн алдагдал буурсантай холбоотой. Харин 2000, 2002 онуудад энэ үзүүлэлт бусад онуудаас өсч байгаа нь төсвийн бүтэц алдагдалд хүчтэй нөлөөлсөнийг харуулж байна. Ялангуяа зарлагын нөлөөлөл ихэссэн нь орлогын өсөлт зарлагаас эрс хоцорсонтой холбоотой гэж үзэж байна. Төсвийн алдагдлын гол шалтгаан нь зарлагын өсөлт боловч орлогын нөлөөллийг давхар тооцох нь чухал юм. Ер нь төсвийн алдагдлын гол шалтгааныг зарлагад тохож, орлогыг орхигдуулах явдал төсвийн бодлогод ажиглагдаж байна. Нөлөөллийг математик статистикийн аргаар судалж тогтоох нь таамаглалыг улам баталгаажуулах, далд нөлөөллийг илрүүлэх чухал ач холбогдолтой. Нөлөөллийн судалгааг нөлөөллийн түвшинд авч үзлээ.

1. Төсвийн алдагдлын ерөнхий судалгаа

	Y	X2	X3
1995	-7.9	22.7	12.5
1997	-9.1	24.3	11.4
1998	14.2	41.9	14.6
1999	11.3	29.4	12.3
2000	-7.7	42.2	11.3
2001	-4.3	42.9	11
2002	-5.9	44.4	10.9
2003	-4.2	42.1	12.4
2004	-2.2	41.6	11.8
2005	-1	22.4	9.1

SUMMARY OUTPUT

Regression Statistics	
Multiple R	0.5733973
R Square	0.3310826
Adjusted R Square	0.1399634
Standard Error	7.4374474
Observations	10

ANOVA

	df	SS	MS	F	Significance F
Regression	2	194.235917	97.118	1.7323	0.244793625
Residual	7	392.433083	56.062		
Total	9	586.669			

	Coefficients	Standard Error	t Stat	P-value	Lower 95%	Upper 95%	Lower 95.0%	Upper 95.0%
Intercept	-55.7871216	22.41251419	-2.489248	0.0379782	-104.0093507	-22.0550732	-104.009351	-22.0550732
X1	0.459945222	0.641440261	0.7123747	0.4992821	-1.058219274	1.97071302	-1.05821927	1.97071302
X2	0.045753298	1.753262947	1.7256295	0.1219902	-1.104007495	2.195296991	-1.1040075	2.195296991

Y-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн алдагдал

X2-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн нийт зардал

X3-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хөрөнгийн зардал ба цэвэр үзэл

2. Төсвийн алдагдлын судалгаа

	Y	X2	X3
1995	-7.9	24.3	22.7
1997	-9.1	25.3	24.3
1998	-14.2	27.9	41.9
1999	-11.3	24.4	29.4
2000	-7.7	29.4	42.2
2001	-4.3	28.4	42.9
2002	-5.9	27.9	44.4
2003	-4.2	29.4	42.1
2004	-2.2	22.8	41.6
2005	-1	22.4	24.3

SUMMARY OUTPUT

Regression Statistics	
Multiple R	0.727482172
R Square	0.529221763
Adjusted R Square	0.294725353
Standard Error	0.520223745
Observations	10

ANOVA

	df	SS	MS	F	Significance F
Regression	2	97.51977428	48.759887	29.246562	0.001505494
Residual	7	26.74422572	3.820604		
Total	9	124.262			

	Coefficients	Standard Error	t Stat	P-value	Lower 95%	Upper 95%	Lower 95.0%	Upper 95.0%
Intercept	-55.7871216	11.10302297	-4.93729	0.0000092	-78.11552612	-33.45871708	-78.11552612	-33.45871708
X2	0.705472727	0.251877457	2.8002609	0.024915	0.199273125	1.201672329	0.199273125	1.201672329
X3	-0.409222257	0.250425202	-1.633934	0.1301092	-1.109246524	0.29060201	-1.10924652	0.29060201

Y-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн алдагдлын хувь

X2-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн нийт орлогын хувь

X3-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн зарлагын хувь

Төсвийн судалгааны нэгтгэл

Хүчин зүйлс	Дет /коф	Кор /коф	Регрессийн тэгшитгэл	F	F шинжүүр
Хавсралт1					
Y-ДНБ-д эзлэх төсвийн алдаг					
Дал	0.331	0.57	$Y=55.787+0.456 \cdot x_2+0.46 \cdot x_3$	1.73	0.24
X2-ДНБ-д төсвийн нийт зардал					
X3-ДНБ-д эзлэх хөрөнгийн зардал ба цэвэр үзэл					
Хавсралт 2					
Y-ДНБ-д эзлэх төсвийн алдагдлын хувь					
X2-ДНБ-д төсвийн нийт орлогын хувь	0.529	0.72	$Y=5.151-0.705 \cdot x_2+0.64 \cdot x_3$	3.93	0.071
X3-ДНБ-д эзлэх зарлагын хувь					

Төсвийн судалгааны дүгнэлт

ДНБ-нд эзлэх төсвийн алдагдалд ДНБ-ний эзлэх хувь, мөн алдагдалд орлого зарлагын далд нөлөөллийг EXCEL программын тусламжтайгаар регресс, корреляцийн тэгшитгэлийг ашиглан гаргахад дараах байдалтай байна.

Хавсралт-1д ДНБ-нд эзлэх төсвийн алдагдалд ДНБ-нд эзлэх төсвийн нийт зарлага ба хөрөнгийн зардал цэвэр зээлийн хувийн жингийн нөлөөллийг шинжилсэн судалгааны дүнг харууллаа. Үүнээс харахад олон хүчин зүйлсийн хамтын нөлөөлөл хүчтэй байгаа нь 0.482 байгаа нь детерминацийн коэффициент, 0.69 байгаа нь корреляцийн коэффициентууд илтгэж байна. Төсвийн нийт алдагдал болон төсвийн зарлага хоёр хоорондоо 86.2 %-н хамааралтай байхад нийт зарлага ба цэвэр зээл нь хоорондоо 48.2 %-н хамааралтай байна. Y хүчин зүйлийн параметрийг 0.08 магадлалтай, X3 хүчин зүйлийн параметрийг 0.23 магадлалтайгаар тодорхойлсон.

Хавсралт-1-д ДНБ-нд эзлэх төсвийн нийт алдагдлыг эзлэх хувийн жинд ДНБ-нд эзлэх төсвийн орлого зарлагын хувийн жингийн нөлөөллийг судлаж шинжилгээний дүгнэлтийг харууллаа. Судалгааны үр дүнгээс харахад детерминацийн коэффициент нь 0.52 байгаа нь сонгосон 3-н хүчин зүйлсийн хамтын нөлөөлөл 52.9% байгааг илтгэж байна. Мөн корреляцийн коэффициент нь 0.72 гарсан нь хамтын нөлөөний хүчтэйг харуулж байна. Регрессийн шинжилгээний бодит байдлыг F шинжүүрээр үнэлэхэд 0.71 гарч байна. Төсвийн алдагдалд нийт орлого зарлага хоёр ямар нөлөөллийг хэдэн хувиар үзүүлж байгааг тооцно. Судалгаанд ДНБ-нд төсвийн алдагдал, төсвийн зарлага, төсвийн орлогын эзлэх хувийн жинг хамруулж тооцлоо.

Дээрх хүснэгтээс үзэхэд төсвийн алдагдал гарахад нийт орлого 37.6 хувь, нийт зарлага 33.9 хувь нөлөөлсөн байна. Энэ үзүүлэлт нь

алдагдалд зөвхөн зарлага биш орлого хүчтэй нөлөө үзүүлдгийг харуулж байна. Нөгөө талаар орлого багасгах явдал төсөвт зарлагаас илүү нөлөөлж чадах нь тодорхой. Иймээс дан ганц орлогын өсөлтөөс алдагдал гараагүй. Харин зарлагын тодорхой бууралт алдагдалд мэдэгдэхүйц нөлөөлж байна.

Судалгаанаас үзэхэд ДНБ-ний 100 хувийн өсөлт нь 20 хувийн төсвийн алдагдлыг төсөвт авчирч байна.

Төсвийн алдагдлын динамик өөрчлөлтөөр тухайн улсын эдийн засгийн тогтворжилтийг тодорхойлдог. 1995-2005 оны хоорондох эдийн засгийн тогтворжилтийг тодорхойлбол:

Алдагдлын дундаж ---Ад (386.9124)

Алдагдлын доод хэмжээ---Амин (39.372.8)

Алдагдлын дээд хэмжээ---Амах (83.052.4)


Хэлбэлзлийн хэмжээг тооцвол: $(Ад-Амин):2+(Амах-Ад):2=(Амах-Амин):2 =$ Алдагдал нь жилийн дундажаас 10-20 хувь өсөх юмуу буурвал эдийн засгийг тогтвортой гэж тооцдог. Дээрх судалгаанаас үзэхэд 129.5-тай тэнцэж байна. ЭНэ нь манай эдийн засгийн байдал тогтворгүй байгааг харуулж байна.

Төсөв алдагдалтай гарч болно. Дэлхийн улс орнууд алдагдлыг үндэсний аюулгүй байдлын үүднээс хязгаарладаг. Үндэсний аюулгүй байдлыг хангах үзүүлэлтүүдийн дотор ДНБ-нд төсвийн алдагдал 5%-с хэтэрвэл нэн аюултай.

Төсвийн алдагдлыг эдгээр жилүүдэд хэрхэн нөхөж байсныг үзэх нь чухал юм. 1990-1991 онуудад төсвийн алдагдлын ихээхэн хэсгийг дотоод эх үүсвэрээр нөхөж байсан байна. Ийнхүү дотоод эх үүсвэрийг хэт дайчилсанаас эдийн засагт очих хөрөнгө багассан байна. Яваандаа дотоод эх үүсвэрээр нөхөх явдал буурч 1997-1999 онуудад голлон гадаад эх үүсвэрээр, тэр дундаа санхүүгийн зээлээр нөхөж байснаас гадна монгол банк, банкны системээс их хэмжээний зээл авч нөхөж байсан. Харин 2000-2002 онд банкны систем дэх өрийг барагдуулж, дотоод эх үүсвэрийг багасгаж, сар улирлын чанартай түр санхүүжилтийг засгийн газрын богино хугацаат бонд гарган хангаж байна.

Төсвийн алдагдлыг нөхөх дотоод эх үүсвэр дайчлах зорилгоор 1996 оноос засгийн газрын бонд гаргасан нь зах зээлийн эдийн засгийн санхүүжилтийн шинэ хэрэгслэлийг эзэмшихэд чиглэсэн алхам байсан юм. Бонд өрийн бичгийн хүү төсвийн зарлагад 1998 онд 3.5%, 2002 онд 3.1%, 2003 онд 50 тэрбум, 2004 онд 61 тэрбум, 2005 онд 44 тэрбум төгрөгийн бонд тус тус гаргасан байна. Гэвч төсвийн орлогын баазыг нэмэгдүүлэх орлогын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг сайн зохион байгуулахгүйгээр их хэмжээний өрийн бичиг, бонд гаргаж үнэтэйгээр мөнгө зээлдэж төсвийн зарлагыг санхүүжүүлэх нь цаад утгаараа эдийн засагт баталгаагүй мөнгө нийлүүлж, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж инфляци бий болж үнэ өсөхөд хүргэх сөрөг үр дагавартай асуудал болохыг анхаарч үзэх нь чухал.

Төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь



(Шилжилтийн орнууд 1995-2004)

Шилжилтийн бүх л орнуудад төсвийн тогтолцоог сайжруулах шаардлага гарч ирсэн. Иймээс олон оронд 3 үндсэн бүрэлдэхүүн хэсгийг авч үзсэн байна.

- Засгийн газрын санхүүгийн байдлыг сайжруулах
- Засгийн газрын зардалын нягтлан бодох бүртгэлийг сайжруулж, шинэчлэх
- Улсын салбарт санхүүгийн зөв удирдлага, төлөвлөлтийг хийх.

Төсвийн алдагдлыг авч үзвэл зүүн европын зарим орнуудад зардалын өндөр түвшин байгаагаас төсвийн алдагдал өндөр түвшинд байна. Эдгээр улсуудад үнэ валютын ханшийг чөлөөлсөнөөр эдийн засаг дахь засгийн газрын тэтгэмжийн хэмжээ огцом буурсан. Ихэнх орнуудад нь батлан хамгаалах салбарт төлөвлөдөг зардал огцом буурсан байдаг. Мөн эдийн засгийн наад захын хэрэгцээ шаардлагын үүднээс хөрөнгийн зардлын хэмжээг бууруулхад хүрсэн байна. Гэтэл зарим төрлийн зардлын ангилалд төсвийн дарамт нэмэгдсэн байна. Тухайлбал улсын өр нэмэгдсэнээс болон зээлийн хүүг чөлөөлсөнөөс хүүгийн төлбөр нэмэгдсэн, зах зээлийн эдийн засаг руу шилжих шилжилтэнд чиглэгдсэн төсвөөс тэтгэмж маягаар шууд зээл олгосон зэрэг төсвийн дарамт өндөр байжээ. Ер нь төсвийн зардлын хэмжээний

бууралтын гол шалтгаан нь засгийн газрын системтэй бодлогын үр дүн тэр болгон биш юм. Төсөвт орж ирэх орлого буурсан мөн инфляцийн бус санхүүжилтээр зардлаа санхүүжүүлэх шаардлагын үүднээс олонх орнуудад өөрийн зардлыг бууруулах шаардлага гарсан юм. Гэхдээ улс төрийн олонх шалтгаанаар тухайн шилжилтийн ихэнх орнуудад тэтгэврийн тогтолцоо хүндрэлтэй байдалд орсон. Учир нь татварын орлого буурсан, тэтгэврийн санд орох тэтгэврийн даатгал төлөгчдийн суурь багассан, мөн нийгмийн зардал буурсан зэрэг олон шалтгаантай. Хүн амын тэтгэвэрт гарах насны хязгаар доогуур тогтоогдогоос эдгээр орнуудад эдийн засагт ажиллагсадын тоотой харьцуулбал тэтгэвэр авагчдийн тоо өндөр байдаг байна. Иймд тэтгэврийн тогтолцооны дарамтыг бууруулах зорилгоор тэтгэвэрт гарах насыг өөрчлөх, тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан индексжүүлэх, тэтгэмж хүртэх босгыг илүү нарийн хатуу болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлжээ

Төсвийн алдагдлыг нөхөх эх үүсвэр

Зарлага нь давсан нөхцөлд төсвийн алдагдал үүсэх бөгөөд түүнийг нөхөхдөө улс орнууд дараах эх үүсвэрүүдийг өргөн ашигладаг. Үүнд:

1. Гүйлгээнд шинээр мөнгө гаргах
2. Дотоод зээлийн эх үүсвэр
3. Гадаад зээлийн эх үүсвэр
4. Валютын нөөцөө ашиглах
5. Алт болон бусад үнэт металл, түүхий эдээр төсвийн алдагдал нөхөх гэх мэт

Дотоод эх үүсвэр

Төсвийн алдагдлыг бууруулах зорилгоор дараах арга хэрэгслүүдийг ашигладаг. Төсвийн орлого зохицуулалтын хүрээнд

- татварын орлогыг өсгөх
- татварын бус орлогыг өсгөх
- засгийн газрын зардлыг бууруулах

төсвийн зарлага зохицуулалтын хүрээнд

- татаас ба урсгал шилжүүлгийг бууруулах
- өр төлбөрийг бууруулах
- хөрөнгө оруулалтын зардлыг оновчтой болгох

Төсвийн алдагдлыг бууруулах орлогын бодлого

Төсвийн алдагдлыг бууруулахад төсвийн нийт орлогыг нэмэгдүүлэх явдал чухал үүрэгтэй. Улс орнуудын макро эдийн засгийн тогтвортой өсөлт нь төсвийн нийт орлогоор хэмжигдэх бөгөөд орлогын өсөлт зарлагын өсөлтийн хурдыг гүйцэх тохиолдолд тухайн өсөлт алдагдлыг эрс бууруулдаг талтай. Төсвийн орлогыг нийт дүнгээр биш бааз

сууриар өсгөх нь чухал байдаг. Ийм бодлогын хүрээнд хөрөнгө оруулалтын бодлого чухал байр эзэлдэг. Төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилго нь урсгал ба нийт алдагдлыг багасгах, хөрөнгө оруулалтанд тодорхой хэмжээний эх үүсвэр хувиарлах явдал юм. Эдийн засгийн хямралгүй нөхцөлд төсөв нь хэмнэлтээрээ хөрөнгө оруулалтын санхүүжилтийг бүрдүүлж, тогтвортой орлогын суурийг тэлж байх үүрэгтэй.

Татварын орлогыг өсгөх

татварын орлогыг өсгөхдөө татварын хувь хэмжээг нэмэгдүүлвэл татварын дарамт улам ихэснэ харин объектыг нь өсгөх шаардлагатай төсөвт орж буй татварын орлогын ДНБ-д эзлэх хувийн жин 1995 онд 24.6%, 1999 онд 19.5%, 2003 онд 29.6%, 2005 онд 31.2%, 2006 онд 28.6% болсон байна. Цаашид татвар ногдуулж хувь хэмжээний бууруулах чиглэл барьж, татварын орлогын суурь орлого гэж хэлж болох татвар төлөгчдийн орлого ашгийг нэмэгдүүлэх асуудал нь чухал юм. Төсөв татварын орлого сүүлийн жилүүдэд өсөж байгаа нь

- татвар төлөгч аж ахуй нэгжийн тоо хэмжээ мөнгө орлого нь өссөн.
- шууд бус орлогын татварын хүрээ, хэмжээний өсөлт татварын орлого нэмэгдэх гол суурь нь эдийн засгийн бодит салбарыг хөгжүүлэх хүн амын амжиргааны түвшинг явдал юм.
- Татварын бус орлогын хувь түүний боломжит хэмжээнд хүртэл өсгөх нь зүйтэй гэхдээ уг орлогын хэмжээ засгийн газрын тогтоох боломжгүй, тухайн төрийн өмчийн ААН-ийн үр дүнгийн түвшин, төрийн өмчийн эд хөрөнгөөс шалтгаалдаг онцлогтой
- Засгийн газрын хөрөнгийн ба тусламжийн орлогыг нэмэгдүүлэх явдал нь хөгжиж байгаа манай орны хувьд ихээхэн ач холбогдолтой юм. Тусламжийн орлого 1993 оноос эхэлж төсөвт орох болсон ба 1994 онд өсөлт нь 7.9% байснаас 2000 онд 16.1% болж өсчээ гэвч 1999 онд 20.1%-р буурсан явдал нь төсвийн орлогын тогтвортой бус эх үүсвэр гэдгийг харуулж байна. Хөрөнгийн орлогын хувьд өсөлт нь 1995 оноос тогтворжиж эхэлсэнч 1996 онд өмнөх оноос 34 %-р буурч 1998 онд 39% өссөнөөс үзэхэд хөрөнгийн орлого нь мөн л тогтворгүй байжээ. Хөрөнгийн болон тусламжийн орлогын энэ байдал манай улсад олгохоор тохирсон зээл тусламжийн тухайн жилийн байдал болон дэлхийн эдийн засгийн өөрчлөлттэй холбоотой байж болох юм.
- Засгийн газрын хэрэглээ буюу бараа үйлчилгээний зарлага нь манай урсгал зардлын дийлэнх хувийг эзэлдэг билээ. Уг зардлын цаана цалин, НДШ болон бусад зардлууд агуулагддаг. Энэ зардлыг хянаж чадвал урсгал төсвийн ашиг тэр хэмжээгээр нэмэгдэж түүгээрээ хөрөнгийн төсвийн алдагдлыг нөхөх боломжтой юм. Гэвч энэ зардал нь цалинг агуулдаг тул нилээд

мэдрэмжтэй ахиу үйлдэлтэй тулгардаг. Хэрэгжүүлэхэд төвөгтэй арга гэж тооцогддог.

- Санхүүжилт нэмэгдүүлэхийг бүхий л явдалдаа шаарддаг, Төсвийн хөрөнгийг дорвитой хэмжилт төдийлөн гардаггүй Ийм тогтолцооны өөрчлөлт хамаарагдана. Шинэчлэх нь нэн түрүүнд шаардсан хүрээ бол төрийн албаны удирдлага зохион байгуулалтын тогтолцоо юм. Төрийн удирдлагын хүрээний санхүүжилтэд 2005 оны гүйцэтгэлээр төсвийн нийт зардлыг бараг 15%-г нь зарцуулжээ. Энэ нь ДНБ-ний 5%-г эзэлж байна. Энд жилээс жилд бүтэц томорч орон тоо олширч зардал нэмэгдэж төсвийн маш их хөрөнгө урсаж байна.
- Хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах явдал нь манай улсын нийгэм, эдийн засгийн хямралтай байгаа өнөөдөр ярихын ч хэрэггүй асуудал билээ. Дотоод орлого бүхэлдээ дотоодын бүх төрлийн татварын болоод татварын бус орлого, хураамж төлбөрөөс бүрддэг. Ер нь төсвийн орлого нь хоорондоо нарийн уялдаа бүхий татварын орлогод. Татварын бус орлогуудын нийлмэл цогц байдаг. Төсвийн орлогыг нэмэгдүүлэх гол зорилго нь урсгал болоод нийт алдагдлыг басгах хөрөнгө оруулалт тодорхой хэмжээний эх үүсвэр хуваарилах явдал байдаг. Эдийн засгийн хямралын орчинд төсөв нь хэмнэлтээрээ хөрөнгө оруулалтын санхүүжилтийг бүрдүүлэх тогтвортой орлогын үндэс суурийг тэлж байх үүрэгтэй. Дэлхий нийтээр төсвийн орлогыг нэмэгдүүлэх бус харин тогтвортой орлогын бааз суурийг бий болгохоос хамаарч байна.

Төсвийн зардал жилээс жилд нэмэгдэж байна. Төсвийн зарлагын 70 гаруй хувийг урсгал зардал, 20 гаруй хувийг хөрөнгийн болон гадаад дотоод өрийн зардал эзэлж байна. Зардлыг хорогдуулахдаа хамгийн гол нь эдийн засгийн тогтолцооны бүтцийн шинжилгээг хийх замаар зардлыг багасгах хэрэгтэй. 2003 оноос хэрэгжиж байгаа төсвийн санхүүжилтийн шинэчлэл эерэг үр дүн өгч байна.

ДҮГНЭЛТ

Төсвийн алдагдал нь эдийн засгийн тогворжилтийг тодорхойлсон макро эдийн засгийн тодорхойлогч үзүүлэлт юм. Улсын төсвийн орлого зарлагыг тогворжуулан эдийн засгийн тогтолцоог бүрдүүлж чадсан оронд төсөвын алагдал багасаж, аяндаа буурах нөхцөл бүрддэг. Зах зээлд шилжсэн эхний жилүүдэд манай улсад энэ үзүүлэлт нилээд хүнд байдалд байв. Санхүү төсвийн хүндрэл үргэлжилсэн хэвээр эдийн засгийн макро микро түвшинд төлбөрийн чадвар доройтсон өрийн гурвалжин сүлжээнд автагдаж, алдагдал ДНБ-нд 1997-1999 онуудад ДНБ-ний 10-12 хувьтай тэнцэж байлаа. Алдагдал өсөх гол шалтгаан нь үндэсний эдийн засагаас орох орлогын бууралт төрийн зарлагын үр ашиг багатай хэт өсөлт бөгөөд өөрөөр хэлбэл төсвийн дотоод тэнцвэр алдагдсан. Үүний нөгөө талаар улс төрийн байдал тогтворгүй засгийн газар олон дахин солигдож энэ нь санхүү төсөв мөнгө-зээлийн тогтолцоонд субъектив хандлага сөрөг нөлөө үзүүлж байсан. Харин 2000 оноос эхэлж эдийн засаг болон санхүү төсөв-мөнгө зээлийн тогтолцоонд ахицтай өөрчлөлт гарч тодорхой үр дүнд хүрсэн. 2002 оноос "Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай" шинэ хуулийг хэрэгжүүлж түүнтэй уялдаж төсвийг төрийн сангийн нэгдсэн дансаар удирдах болсон. Энэ хугацаанд төсвийн алдагдал туйлын ба харьцангуй хэмжээгээрээ буурах хандлагад орсон. Мөн үндэсний үйлдвэрлэл сэргэж эдийн засгийн өсөлт тогтворжиж татвар төлөгчдийн санхүүгийн чадавхи дээшилсэн. Үүний зэрэгцээ олон улсын зах зээл дээр манай орны экспортын гол бүтээгдэхүүн болох алт зэс ноолуурын үнэ өсөж аятай нөхцлийг бүрдүүлсэн. Дээрх арга хэмжээний үр дүнд

- Төсвийн орлого ялангуяа татвар төлөлт сайжирч өсөлт нь түрэгсэж төсвийн чадавхи дээшилсэн.
- Төсвийн зарлагын санхүүжилт цаг хугацаандаа бүрэн хийгдэх болж түүний гүйцэтгэлд тавих бүртгэл хяналт тогтмолжиж төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашигт нааштай өөрчлөлт орж байна.
- Урсгал төсвийн тэнцэл батжиж сүүлийн жилүүдэд нийт төсвийн алдагдал багасан ДНБ-нд түүний эзлэх хувь 5 хувиас хэтрэхгүй улмаар 2004 онд ДНБ-нд 2.2 хувь болж улмаар 2005 онд төсвийн нийт тэнцэл 70 гаруй тэрбум төгрөгийн ашигтай гарсан. 2006 оны төлөвлөлтөөр алдагдал ДНБ-нд 3.4 хувиар төлөвлөгдөв. Гэхдээ 2006 оны төсвийн гүйцэтгэлийн 5 сарын 1-ны байдлаар нийт тэнцэл нь 40 гаруй тэрбум төгрөгийн ашигтай

гарч байна. Дүгнэхэд улсын санхүүгийн байдал сайжирч орлогын өсөлт нь хурдасч бэхжих төлөвт орж байна.

Төсвийн алдагдал нь цэвэр санхүүгийн асуудал биш бөгөөд алдагдлыг цэвэр санхүү-төсвийн аргаар арилгах боломжгүй. Төсвийн алдагдлыг бууруулахад дараах асуудлыг бодолцох нь зүйтэй.

1. *Инфляцийн өнөөгийн нөхцөлд* алдагдалгүй төсөв бий болгох нь онолын хувьд ч практикийн хувьд ч ямар ч боломжгүй юм. Гэхдээ манай орны хувьд төсвийн алдагдлыг тогтвортой нэг түвшинд барьж байх нь чухал.
2. *Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх* замаар алдагдлыг бууруулж огт болохгүй. Энэ нь татвар төлөгчдөд эргээд дарамт болно. Харин татварын бааз суурийг /нэр төрлийг/ нэмэгдүүлж болох юм. Иймээс үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж монголын эдийн засгийн гол чадавхи болгон хөгжүүлж татвар ногдуулах суурь орлогыг нэмэгдүүлэх нь чухал. Мөн татварын бус орлогыг нэмэгдүүлэх хэрэгтэй.
3. *Гадаад зээл тусламжаар* Төсвийн алдагдлыг нөхөхөөр гадаад ба дотоодын томоохон хэмжээний зээлд найдах нь цаашдаа улсын төлөх өрийг нэмэгдүүлнэ. Эргээд засгийн газар их хэмжээний санхүүгийн эрсдэлд орно. Манай улс 1960-д оноос эхлэн одоог хүртэл энэ аргыг хэрэглэж өрөө 2001 оноос эхлэн төлж байна. Одоогийн байдлаар ДНБ-нийхээ 80 хувьтай тэнцэх хэмжээний өртэй болсон идэвхтэй зээлдэгч орнуудын нэг юм. Иймээс гадаад зээл тусламжийн ашиглалтад өндөр хяналт тавих нэг хяналтын тогтолцоог бүрдүүлэх явдал чухал байна.
4. Төрийн зээл /засгийн газрын/Банкнаас зээл авах явдал сүүлийн 3-н жилд гараагүй. Харин засгийн газрын бонд гаргаж борлуулсан алдагдлыг нөхөх, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга нилээд чухал.
5. Төсвийн зарлагыг бууруулах явдал алдагдлыг бууруулах найдвартай эх үүсвэр болох бөгөөд зарлага жил тутам өсч байдаг. Харин 2005 онд урсгал зардал 72.8 хувь хөрөнгийн зардал 11.9 хувийг эзлэж байна. Зарлагыг ойр зуурын орон тоо зардал шууд хасах замаар хорогдуулах нь ямарч нөлөө үзүүлэхгүй нь тодорхой байна. Хамгийн гол нь нийгэм эдийн засгийн тогтолцоонд бүтцийн шинэчлэл хийх замаар зардлыг багасгах хэрэгтэй.

Манай орны хувьд төр засгийн удирдлага зохион байгуулалтанд бүтцийн өөрчлөлт хийж, удирдлагын зардлыг бууруулвал зарлагыг хямдруулах, алдагдлыг багасгах боломж бий гэж үзэж байна

Ашигласан материал

1. Б.Энхбаяр, Л.Отгонтуяа. "Төрийн санхүүгийн удирдлага" УБ 2002
2. Д.Моломжамц "Санхүү мөнгө зээлийн харилцаа" УБ 2006 он
3. Д.Цэрэнпил "санхүүгийн шинэчлэл" УБ 2006
4. Л.Оюун, Д.Цэрэнпил "Мөнгө зээлийн бодлогын онолын үндэс" (III боть) УБ 2005
5. С. Нямзагд, Г. Алтанзаяа "Татвар, татвар ноогдолт" УБ 2004
6. Ц. Аюурзана "Аж ахуй нэгжийн санхүү" УБ 2001
7. Ц. Аюурзана "Хөрөнгө оруулалт. Бодлого эрх зүйн зохицуулалт, төлөвлөлт, санхүүжилт" УБ 2005
8. Д.Намжил."Төрийн санхүү" УБ 2002
9. С. Баатар, Ганхөлөг "Татварын онол арга зүйн зарчим асуудлууд" 2000
10. СЭЗ яам "Монгол улсын эдийн засаг нийгмийн хөгжил 2000-2004 он" УБ
11. Ерөнхийлөгчийн хэвлэл мэдээллийн алба "Монголын эдийн засаг XI зуун онол практикийн бага хурал, илтгэлийн эмхтгэл" УБ 2005
12. МУИС-ЭЗС "Мөнгө санхүү" сэтгүүл 2004-2006
13. Монгол улсын төсвийн тухай хууль 1997
14. Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль 2002
15. СЭЗ яам 1990-2005 оны улсын төсвийн гүйцэтгэлийн танилцуулга
16. 2006 оны улсын төслийн танилцуулга
17. Монгол улсын татварын тухай хуулиуд болон тэдгээрийн нэмэлт өөрчлөлтүүд УБ 1997, 2004 он
18. "Экономика государственного сектора" Дж.Ю.Стиглиц. 1997 г.
19. "Государственный бюджет" В.В. Журавлев. Н.Савруков. 2000г.
20. "Бюджетная система российской" 1999 г.

Web sites:

www.imf.org

www.worldbank.org

www.fta.org

www.wto.org